



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/16

Жаргалтхаан сум

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд 2026 онд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх “Инженерийн шугам сүлжээ нэмэгдүүлэх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Отгонбаяр – Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Г.Жавзанжамъян – 1 дүгээр багийн Засаг дарга

Гишүүд: М.Ундрал – Хөдөлмөр, халамж үйлчилгээний

асуудал хариуцсан мэргэжилтэн


Г.Түмэнжаргал- Байгаль орчны асуудал

хариуцсан мэргэжилтэн

Н.Ууганбаяр- Газрын даамал

2.Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд чанартай зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан гэрээ байгуулах, бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг үнэлгээний хороо (Н.Отгонбаяр)-д даалгасугай.

ДАРГА



С.ГАНБАТ